

**1912 ОНЫ ОРОС-МОНГОЛЫН ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАГДАХАД
НӨЛӨӨЛСӨН ГЕОПОЛИТИКИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ (ГЕРМАНЫ
ГАДААД ХЭРГИЙН ЯАМНЫ БАРИМТ БИЧГҮҮДЭД ТУЛГУУРЛАН
НЭХЭН АВЧ ҮЗЭХҮЙД)**

УДО Б. БАРКМАНН

Товч агуулга. 1912 оны Монгол-Оросын хэлэлцээрийн талаарх судалгаа одоогоор хэлэлцээний явц болон хэлэлцээрийн текстийн тайлбарт төвлөрч байна. Энэхүү өгүүлэлдээ 1912 онд байгуулагдаж, “Монголын асуудал”-ыг шийдвэрлэх эхний алхам болсны зэрэгцээ хожмын Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үндэс суурийг тавьсан Монгол-Оросын хэлэлцээрийн геополитикийн ерөнхий нөхцөлийг судалж үзэхийг оролдлоо. Энэхүү өгүүлэл голчлон тухайн үеийн Герман улсын Гадаад хэргийн яамны (Auswärtiges Amt) баримт бичигт үндэслэсэн.

Түлхүүр үг. “Зүүн Азийн асуудал”, “Монголын асуудал”, Манж Чин улс, Гадаад Монгол, хаант Орос улс, Монголын тусгаар тогтнол, 1912 оны Монгол-Оросын хэлэлцээр, Герман улсын Гадаад хэргийн яамны (Auswärtiges Amt) баримт бичгүүд.

“Зүүн Азийн асуудал”

XIX зууны сүүлч, XX зууны эхээр Германы Ази судлалын ном зохиолуудад “Зүүн Азийн асуудал” багагүй тусгалаа олж, хожим “Солонгосын асуудал”, арай хожуу “Монголын асуудал”, улмаар нийтэд дуулиан багатайхан шиг “Түвдийн асуудал” тусгагдах болжээ.¹ “Солонгосын асуудал”-ын цаана Японы, “Монголын асуудал”-ын цаана Оросын, “Түвдийн асуудал”-ын цаана Их Британийн гэх зэргээр тэрхүү тодорхой “асуудал” нэг бүрийн цаана тодорхой улс гүрнүүдийн ашиг сонирхол байсан. Өөрөөр хэлбэл, “асуудал” нэг бүр нь дэлхий дахины талаарх Германы гадаад бодлогын үзэл баримтлалыг ч бас ямар нэг байдлаар хөндөж байлаа. Солонгос, Ар Монгол, Түвдийг сонирхсон улс гүрнүүдийн сонирхол нь гол төлөв улс төр-эдийн засгийн, гэхдээ бас цэргийн ч ашиг сонирхлын бөөгнөрөл байсан. Юуны өмнө Европын улс гүрнүүд, АНУ, арай хожуу Япон улсын зүгээс Манж-Хятадын эзэнт гүрэн буюу Манж Чин

¹ M. von Brandt. *Ostasiatische Fragen. China. Japan. Korea. Altes und Neues*. Berlin, 1897. 359

улс, түүний бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд хандах хандлага “Зүүн Азийн асуудал”-ын гол цөм болж байв. Дээр нь бас Чин гүрний Хятад төвтэй батлан хамгаалах загварт Хятадын голомт нутгийг хамгаалах гэдэг утгаараа онц чухал үүрэг гүйцэтгэж байсан Хятадын гаднах нутгуудыг эцэстээ “уусах”-д хүргэж мэдэх “Монгол” болон “Түвдийн асуудал” Хятадын хувьд ноцтой аюулыг өөртөө агуулж байсан юм (Өнөөдөр ч гэсэн зарим геополитикч Хятадыг зах зухаас нь “уусгах” нь хамгийн хялбар хэмээн үзэж буй). Энэхүү өгүүлэлдээ 1912 онд байгуулагдаж, “Монголын асуудал”-ыг шийдвэрлэх эхний алхам болсны зэрэгцээ хожмын Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын үндэс суурийг тавьсан Орос-Монголын хэлэлцээрийн геополитикийн ерөнхий нөхцөлийг судалж үзэхийг оролдлоо.

“Зүүн Азийн асуудал” чухам яагаад үүсэх болов?

1814-1815 онд Венийн Их хурлаар “Улс гүрнүүдийн Европын концерт”-ын системийг бий болгосон. Тэрхүү “Европын концерт” нь үндсэндээ олон улсын харилцаанд олон туйлт системийн үүрэг гүйцэтгэх болсон байна. Англи, Франц, Австри, Орос, Прусс их гүрнүүд “Европ, улмаар даян дэлхийн энх тайван”²-ы баталгааг хангах болжээ. Яаж түүнийг хангах болов? Тэдгээр улс хэдийгээр хоорондоо өрсөлддөг ч гэсэн өөр хоорондын “хүчний тэнцвэр” болон статус квог хадгалах асуудлаар харилцан ойлголцдог байлаа. Энэ байдлаа хэрхэн хадгалж байсан бэ? Тэнцвэрийг барихдаа “Нэг их гүрний хүч нэмэгдэх бүрд бусад бүх их гүрний хүчийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэх замаар түүнийг нөхөн тэнцүүлэх” ёстой байжээ.³ Гэхдээ “Нөхөн тэнцвэржүүлэх энэ тоглоомоор тоглох утгвар нөхцөл” нь “газарзүйн хийгээд эрх мэдлээ хадгалах бодлого явуулах орон зай Европын гадна”⁴ байх явдал байж. Энэтхэгийн дэд тив нэгэнтээ Английн нөлөөлөл, ашиг сонирхлын бүс болоод байсан тул (Их Британи нь тухайн үеийн ойлголтоор цорын ганц “супер гүрэн” байсан) улс гүрнүүдийн өргөжин тэлэх ашиг сонирхол Манж Чин улсын захиргаанд байсан Хятадад аяндаа чиглэх болжээ. Хятадын хэмжээ дамжаа, баялаг, тус улс бас асар том борлуулалтын зах зээл байсан явдал түүнд нь дэм өгсөн.

Дэлхий хийгээд далайн их гүрэн Их Британи Хар тамхины I дайн (1839-1842), арай хожуу Хар тамхины II дайнаар (1856-1860) Францтай хамтран Хятадыг хагас хугас нээлттэй болгосон юм. Бараг тэр үед Орос улс Крымийн дайныг (1853-1856) хийж, эцэст нь Османы эзэнт гүрний эсрэг (1877-1878) дайтахад Европын гүрнүүд Оросын эсрэг Константинополийг дэмжиж байв. 1871 онд Герман-Францын дайны үр дүнд Германы эзэнт гүрэн байгуулагджээ. Отто фон Бисмарк Францын Версалийн ордны Тольт танхимд Пруссын I Вильхелм хааныг эзэн хаанд өргөмжилсөн тунхагийг уншин сонсгож байлаа. Хуучин Европын гүрэн Пруссын оронд Германы эзэнт гүрэн гарч ирж, тун удалгүй улс төр, эдийн засгийн хувьд асар их хүчирхэгжив.

² Stephan Hobe, Otto Kimminich. *Einführung in das Völkerrecht*. Tübingen und Basel, 2004. 40

³ Мөн тэнд, 41.

⁴ Мөн тэнд.

Орос улсын дайнууд ба Германы нэгдэл нь Европын “хүчний тэнцвэр”-ийг ихээхэн алдагдуулсан билээ. Тэр ч байтугай Киссинжер тэр үеийн Германыг “бүх хөршөө тус бүрд нь, магад ч үгүй тивийн бүх улс гүрнийг бүгдийг нь ялах хангалттай хүч чадал бүхий зонхилогч улс”⁵ гэж үзэж байсан юм. Орос, Герман хоёр улс тэгээд “Улс гүрнүүдийн Европын концерт”-оос гарсан. “Европын концерт”-ийн дэглэм үндсэндээ хүчингүй болжээ.

Үйл явдлын энэ өрнөл “Зүүн Азийн асуудал”-д багагүй нөлөө үзүүлсэн. Ингээд Европын улс гүрнүүд Хятадад чөлөөтэй худалдаа хийж байх, сонирхлын хүрээгээ тодорхойлох, түрээсийн газар нутаг олж авах, борлуулалтын зах зээлтэй болох гэж ухаан жолоогүй тэмүүлэх болжээ.⁶ Энэ нь Их Британи, Чин гүрний хооронд байгуулсан Нанжины (Nanjing/1842), АНУ, Чин гүрний хооронд байгуулсан Вансягийн (Wangxia/1844) зэрэг тэгш бус гэрээнүүдээс ч тодорхой харагдаж байв.

Юуны өмнө тухайн цаг үеийн аж үйлдвэр өндөр хөгжсөн Англи орон Хятадын талаарх бодлогоо улс төрийн зорилгын хажуугаар (Энэтхэг дэд вант улс нь байсан болохоор Их Британи бас Хятадын газар зүйн шууд хөрш болж байв) юун түрүүнд эдийн засгийн зорилгод чиглүүлж байлаа. 1895 онд Лорд Солсбери “Англи улс дэлхийн хагас иргэншсэн болон иргэншээгүй улс үндэстнүүдийн дотор борлуулалтын шинэ зах зээл нээх зайлшгүй шаардлагатай”⁷ хэмээн мэдэгдэж байв. Хэт их үйлдвэрлэлийг багагүй явуулж байсан болохоор Британийн аж үйлдвэрт тэдгээр зах зээл хэрэгтэй байжээ. Түүний зэрэгцээ Европын банкууд хөрөнгөө ашиг өгөхүйц зүйлд оруулах зохистой боломжийг эрж хайж байсан агаад газарзүй болон хүн амынхаа хэмжээ дамжаагаар Хятад улс тэдэнд онцгой тохиромжтой санагдаж байв. Тэр ч байтугай Британийн зарим сонин тэр үед Хятадыг Британийн ивээл хамгаалалд авахыг шаардаж байлаа. Английн аж үйлдвэрийн хувьсгал, капиталист хөгжлийн үр дүн нь хариу төлөөс нэхэх болсон хэрэг. Үндсэндээ капиталист системийн дотоод хөдөлгөгч хүч нь хэтдээ “хүчний тэнцвэр”-ийн аливаа хэлбэрийг эргэлзээтэй болгосон юм.

Өрнө дахины ноёлогч дэг журам болсон олон улсын сонгодог эрх зүй

Европын их гүрнүүд Зүүн Азид нэвтэрснээр хоёр болон олон талт харилцааг, жишээ нь Манж Чин улстай нэгдсэн нэг стандартын дагуу баталгаатай зохицуулах шаардлага бий болжээ. Улс гүрнүүд олон улсын харилцаандаа олон улсын сонгодог эрх зүйн зарчмуудыг үндэс болгон холбогдох гэрээ хэлэлцээрүүдийг боловсруулах болов. Нийтлэг улс төр, үзэл суртал бүхий Европын улс гүрнүүд тэрхүү олон улсын сонгодог эрх зүйг урт удаан хугацааны үйл явцад (1648 оны Вестфалийн энхийн гэрээ, 1731 оны Ютрехтын гэрээ, Эрх мэдлийн тэнцвэрийн зарчим, 1814/15 оны Венийн их хурал, Конгрессын систем, Ариун холбоо, 1899, 1907 оны Гаагийн энх тайвны бага хурлууд) боловсруулан хөгжүүлсэн юм. Түүнээс өмнө Зүүн Азид олон улсын эрх зүйн дүрэм журам

⁵ Henry Kissinger. *Weltordnung*. München, 2014, 92.

⁶ F.E.A.Krause. *Geschichte Ostasiens*. Göttingen, 1925, 272.

⁷ M. von Brandt. *Das Kabinett Salisbury und die ostasiatische Frage* (1895), M. von Brandt. *Ostasiatische Fragen. China. Japan. Korea. Altes und Neues*. Berlin, 1897, 283.

гэхээр юм эхлэлийн төдий ч байгаагүй тул аяндаа Европын олон улсын сонгодог эрх зүйн үндсэн дээр гэрээ хэлэлцээ хийх болсон байна. Энэ нь жишээ нь, Хятад дахь Чин улсын Засгийн газар олон улсын эрх зүйн тэдгээр зарчимтай танилцаж, тэдгээрийг бас хүлээн зөвшөөрөх ёстой гэсэн үг байв. Энэ тал дээр Хенри Вийтоны “Олон улсын эрх зүйн элементүүд” болон И. К. Блунчлийн “Иргэншсэн улсуудын орчин үеийн олон улсын эрх зүйн эрх зүйн ном дор тайлбарлахуй” зэрэг бүтээлүүд цагтаа “орчин үеийн” олон улсын эрх зүйн хамгийн чухал ном болж гаргууд үүрэг гүйцэтгэсэн юм.⁸ Тэдгээр бүтээлийг 1865 болон 1880 онд хятад хэлэнд, хожим нь япон, монгол хэлнээ орчуулжээ.

Олон улсын эрх зүйн гол цөм нь улс орнуудын бүрэн эрхт тэгш байдлын зарчим байв. Нэг улс орон хуулийн этгээд болохыг нь олон улсын эрх зүйн дагуу хүлээн зөвшөөрсөн нөгөө улстай л гэрээ юм уу, хэлэлцээр байгуулах боломжтой байсан болохоор тийм зарчим зайлшгүй хэрэгтэй байсан. Гэсэн хэдий ч эрх зүйн практик дээр Европын улс гүрнүүд өөрсдийгөө жишээ нь Хятадаас илүү адил тэгш гэж үзэж байснаас үндсэндээ эрх мэдэл, хүч чадлын байр сууринаас хэлэлцэж хийсэн гэрээ бүр нь тэгш бус болохоос ч өөр аргагүй байлаа. Энэ нь эцэстээ Хятад юм уу, бусад гэрээт талуудын бүрэн эрхийн хэр хэмжээг Европын улс гүрнүүд (+АНУ, +Япон) шийдэж байсан гэсэн үг юм.

“Нээлттэй хаалганы зарчим”

Уг чанартаа эдийн засгийн шинжтэй Европын улс гүрнүүдийн санаа зорилго их, бага ямар нэг хэмжээгээр Хятадын бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг чиглэж байсан бол АНУ 1899, 1900 онд “нээлттэй хаалга”-ны (Open Door) зарчмаар цоо шинэ бодлого баримтлах болсноо тунхаглаж, 1945 оныг хүртэл түүнийг гадаад бодлогынхоо нэгэн тулгуур багана болгосон билээ. Хятад-Японы дайн (1894-1895) улс гүрнүүдийг Хятадад нөлөөллийнхөө хүрээг тогтоохын төлөө ихээхэн өрсөлдөхөд хүргэв. Хятадад байр сууриа нэгэнт олсон улс гүрнүүд худалдаа, хөрөнгө оруулалтын онц эрхийг монопольчлоод авчихаж болох байснаас АНУ эдийн засгийн ашиг сонирхлоо хэрэгжүүлж чадахаа больчих вий хэмээн эмээж байлаа. Хятадыг колониудад хувааж мэдэхээр болсон нь АНУ-ын эдийн засгийн хувьд Хятадын зах зээлд нэвтрэх боломжоо алдана гэсэн үг байв. Тиймээс 1899 онд АНУ-ын гадаад хэргийн сайд Жон Хэй (John Hay) Хятадад “ашиг сонирхол, нөлөөллийн хүрээгээ тогтоох санаархал бүхий улс гүрнүүд”-эд хандан дараах шаардлагуудыг тавьжээ:

1. “Гэрээт боомт буюу ашиг сонирхлын хүрээ гэгч буюу түрээсэлсэн нутаг дэвсгэр”-ийн доторхи хууль ёсны ашиг сонирхолд ямар нэг байдлаар хөндлөнгөөс хутгалдан оролцохгүй байх;

2. “Нэр заасан “ашиг сонирхлын хүрээ”-н дэх боомтуудад буулгасан буюу усан онгоцоор тээвэрлэн авчирсан бүх бараанд ... Хятадын гэрээт үнэ тарифыг мөрдөх”;

⁸ Henry Wheaton, Elements of International Law, Philadelphia 1836. J.C.Bluntschli. *Das moderne Völkerrecht der Civilisirten Staaten als Rechtsbuch dargestellt*. Nördlingen 1869.

3. Боомт болон төмөр замын төлбөр хураамж, тэрчлэн ашиг сонирхол болон нөлөөллийн хүрээгээр дамжин өнгөрөх транзит тээврийн асуудалд улс үндэстнүүдийг адил тэгш авч үзэх.⁹

АНУ-ын гадаад хэргийн сайд 1900 оны 7-р сарын 3-ны өдрийн тараах бичигтээ 1. Хятадын нутаг дэвсгэр, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хэвээр хадгалах, 2. Найрсаг улс гүрнүүдэд гэрээ болон олон улсын эрх зүйн дагуу баталгаажуулж өгсөн бүх эрхийг хамгаалах, 3. Хятадын эзэнт гүрний бүх бүрэлдэхүүн хэсэгтэй эрх тэгш, тал тохой таталгүй худалдаа хийх зарчмыг баталгаажуулах зэрэг шаардлагыг тавьсан байна.¹⁰ Их Британи, Герман, Франц, Япон, Италийн Засгийн газрууд “нээлттэй хаалга”-ны бодлогыг амаар дуртай дургүй зөвшөөрчээ. Харин Орос улс хариу өгсөн боловч зөвшөөрлөө тодорхой илэрхийлээгүй байна.

Орос, Япон улсууд нутаг дэвсгэрийг албадан хавсаргах бараг уламжлал болсон бодлогоо удалгүй Зүүн Азид цааш нь үргэлжлүүлж эхэлсэн билээ.

“Зүүн Азийн асуудал” ба дэлхийн бодлого

Гэхдээ дэлхийн улс төрийн бодлого ч “Зүүн Азийн асуудал”-д мөн нөлөөгөө үзүүлэх болсон. Далайн их гүрэн Их Британи эх газрын их гүрэн Оросыг “Британийн дэлхийн ноёрхолд хамгийн их аюултай дайсагнагч” гэж үзэж байсан тул (өнөөгийн нөхцөл байдлыг санагдуулам) 1902 онд холбоо байгуулах замаар Японыг Оросын эсрэг дайн хийхэд хөгжөөн дэмжсэн юм. Лондоны стратегийн тооцоо Оросоор цэргийн хүчийг нь Европ бус, Алс Дорнодод тогтоон бариулж байхад чиглэж байлаа (Энэ ч бас өнөөдөр эцэст нь гуравдагч талыг сулруулах гэсэн зарим нэг талын санаа байж болох). Ингээд Орос улс Японтой дайтав. Орос улс Цushimaд флотынхоо үлэмж хэсгийг алдаж, ялагдал хүлээжээ. 1905 онд Орос, Япон улсууд Портсмутын энхийн хэлэлцээрийг байгуулав. Хэлэлцээрт Оросын талыг тэргүүлж байсан Виттегийн нарийн бичгийн даргын хувиар бидний сайн мэдэх И.Я. Коростовец оролцжээ. Түүний дараачаас Их Британи Алс Дорнод дахь флотынхоо хэмжээг үлэмж багасгаж, Европын далай тэнгист хүч нэмж болохоор боллоо гэж үзжээ. Орос харин их гүрний хувьд Хятадын элитүүдийн дунд нэр хүндээ өнө удаан сэвтээснээ хүлээхээс өөр аргагүй болсон. Хятадын Засгийн газрын бодлогыг сэргэж буй үндэсний ухамсар, гадаад гүрнүүдийн эсрэг чиглэсэн шовонизм улам бүр тодорхойлох болов. Энэ нь “Чин улсын шинэ засгийн бодлого”-той (Хятадын колоничлол, Манжуур, Ар Монгол, Түвдийг засаг захиргааны хувьд улам бүр нэгтгэх) нийлээд Оросын гадаад бодлогод ихээхэн төвөг удах болсон нь Оросын Эзэн хааны Гадаад хэргийн яамны баримт бичгээс харагдана. Тэгээд ч Европын гүрэн болохын хувьд Орос улс нь Европт тулгараад байсан асуудлуудын улмаас “Зүүн Азийн хэрэг явдал”-д хамаа намаагүй хутгалдан оролцож чадахаа болиод байсан.

⁹ <https://courses.knox.edu/hist245/opendoortext.html>

¹⁰ Open Door policy United States-China (1899-1900), in <https://www.britannica.com/event/Open-Door-Policy>

Зүүн Ази дахь их гүрнүүдийн ашиг сонирхол туйлшрах байдалд орж эхлэв. Нэг тал нь Их Британи, Орос, Франц, Япон улс, нөгөө тал нь АНУ, Герман, Хятад улс болж байлаа. Орос, Их Британи улсууд харилцаагаа дахин хэвийн болгоод зогссонгүй. Орос улс 1907 онд Англи-Францын Антантын (Entente) гэрээнд бас нэгдэн орсон агаад тэр нь их бага ямар нэг хэмжээгээр Германы эсрэг чиглэсэн “Гурвалсан Антант” (Triple Entente) болж хувирсан билээ. Мөн 1907 онд хоёр тал конвенци гарган Түвдийн асуудлаар харилцан ойлголцож, Түвдийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг баталгаажуулсан ч, тус улс Хятадын эзэн эрхийн дор (*suzerainty*) оршихоор болсон юм.¹¹ Ингээд хоёр тал олон жилийн тэртээгээс Төв Азид өөр хоорондоо явуулсныг “Том тоглоом” (Great Game) ч бас дуусгавар болгосон юм. Бусдыг албадан хавсаргахаар төлөвлөөд байсныхаа улмаас Орос, Япон улсууд ч дахин ойртох болов. 1907 онд хоёр тал “Хятадын эзэнт гүрний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал”, “Нээлттэй хаалганы зарчим”-ыг хүлээн зөвшөөрсөн улс төрийн ерөнхий хэлэлцээр байгуулсан авч дагалдах нууц хэлэлцээрээр Манжуур дахь нөлөөллийнхөө хүрээг тогтоон тодорхойлсон байна. Түүгээр Япон улс Ар Монгол ч бас Оросын ашиг сонирхлын хүрээ болохыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Хоёр тал 1910¹² оны хэлэлцээртээ Манжуур дахь ашиг сонирхолдоо анхаарлаа төвлөрүүлжээ. Тэд “Орос, Япон улсуудын хооронд байгуулсан бүх гэрээ, конвенц, хэлэлцээрийн үр дүнд бий болсон” Манжуурын статус квог хэвээр хадгалж, хүндэтгэн үзэх үүрэг хүлээсэн байна.¹³ Харин “Хятадын эзэнт гүрний тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал” болон “Нээлттэй хаалганы зарчим” огт дурдагдсангүй. Хятад судлаач Краузе энэ холбоог “ямар ч үед хамгаалалтын ч, эсэргүүцлийн ч холбоо болон хувирч мэдэх хамгаалалтын холбоо” хэмээн тодорхойлсон буй.¹⁴ Түүний дүгнэснээр, хоёр тал “өөрсдийн хоорондох хурцадмал байдлын улмаас бие биедээ уягдаж хүлэгдэхээ больсон”, мөн аль аль тал нь “нөгөө талаа саад хийнэ гэж хүлээлгүйгээр” өөр өөр зорилгод анхаарлаа хандуулж болохоор болсон нь онц чухал байсан аж.¹⁵ Тэгснээр газар нутгийг албадан хавсаргахаас үл буцах хандлага Орос, Японы гадаад бодлогод ихсэх магадлалтай болжээ.

Орос улс ба “Монголын асуудал”

Хаант Орос улс болон Чин гүрний Засгийн газрууд 1860 онд Бээжингийн гэрээг байгуулж, Ар Монголын “нийслэл” Их Хүрээнд (оросоор Урга) Консулын газраа ажиллуулах эрхийг Орос улсад олгосон бөгөөд Хиагт-Бээжин-Хиагт чиглэлийн Орос, Хятадын худалдааг уг гэрээгээр зохицуулах болжээ. Орос улс 1872 онд Их Хүрээнд Консулын газраа нээсэн байна. 1881 оны Петербургийн гэрээг байгуулснаар Оросын худалдааны сонирхол Ар Монголд улам их чиглэх

¹¹ *British and Foreign States Papers*. 1906-1907, Vol. C, 558-559.

¹² Udo B.Barkmann, *Geschichte der Mongolei*. Bonn, 1999, 85-86.

¹³ F.E.A.Krause. *Geschichte Ostasiens*. Göttingen, 1925, 272.

¹⁴ Мөн тэнд, 276.

¹⁵ Мөн тэнд.

болсон. Уг гэрээгээр “худалдаа наймааг хөгжүүлэх явцад, Хятадын Засгийн газартай тохиролцсоны дагуу” Их Хүрээ, Ховд, Улиастайд Консулын газраа байгуулах эрхийг Орос улсад олгосон байна.¹⁶ Монгол дахь Оросын харьяат албат, хуулийн этгээдүүдэд олгосон эрхүүдэд газар зүйн хувьд хамгийн өргөн утгаар гаалийн татвараас чөлөөлөгдөх, Оросын Консулын газар бүхий газрууд болон Хаалган хотод олж авсан газар дээрээ барилга гэх мэтийг барих эрх орж байв. Хаалганаар дамжуулан Тяньжин боомт руу бараагаа газраар тээвэрлэхийг Оросын худалдаачдад зөвшөөрчээ.¹⁷ Манж Чин улс Европын гүрэн болох Орос улсад тэр цаг үеийн хэмжүүрээр ихээхэн найр тавих ёстой болсон байдаг. Гэсэн ч Орос улс шинээр олж авсан давуу эрхээ амьдралд бараг хэрэгжүүлж чадаагүй юм. Тэгье гэвч Сибирийн эдийн засаг хүчрэхгүй байсан хэрэг.

Харин Транс-Сибирийн төмөр зам баригдсанаар Ар Монголыг оросын цэргийнхэн илүүтэй их сонирхох болжээ. Тус бүс нутагт Манж Чин улсын цэргийн ажиллагаа идэвхэжсэний улмаас Сибирь болон Транс-Сибирийн төмөр замын аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэсэн асуулт тавигдах болж. Оросын цэргийнхэн XVIII зууны дунд үеэс монголчуудын эрх чөлөөг хүссэн хүсэл эрмэлзэл хийгээд Чин улсын Засгийн газрыг мэр сэр эсэргүүцэх болсныг нь сайн мэдэх болсон байна. Энэ нь Сибирийг батлан хамгаалах үзэл баримтлалдаа Ар Монголыг Хятадын эсрэг жийргэвч болгон ашиглах асуудлыг бодолцож үзэхэд хүргэсэн мэт. Тиймээс цэргийнхэн Оросын гадаад улс төрийн бодлоготнуудаас Ар Монголд оролцоогоо нэмэгдүүлэхийг шаардах болжээ. Гэвч гадаад улс төрийн бодлоготнууд нь Европ, Азийн аль алинд нь хандах хандлагаа цэгнэж үзсээр, жийргэвчийн үүрэг гүйцэтгэх талаас нь Ар Монголд төдийлөн ач холбогдол өгөөгүй ажээ.

Оросын Засгийн газар 1905 оны 4-р сарын 14-нд Бээжинд онц бөгөөд бүрэн эрхт сайдаар томилогдсон өөрийн дипломатч Д.Д.Покотиловт Хятадад юуны өмнө Японы байр суурийг анхааралтай ажиглаж байх зааврыг өгчээ. Түүнээс гадна тэр Лхаст буцаж очих боломжийг Далай ламд олгож, түүнийг хуучин зэрэг зиндаанд нь тавих талаар Хятадын Засгийн газарт нөлөө үзүүлэх ёстой байв. “Орос улс өөрт нь цөхрөлтгүй сайн сайхныг хүсч, туслахад цаг ямагт бэлэн байдгийг” Далай ламд тэр батлан хэлэх ёстой байв.¹⁸ Сайд Покотилов Зүүн Сибирээр дайран Хиагтаас Их хүрээ (Урга) хүрч, эцэст нь Бээжинг зорьжээ. Их хүрээнд тэр Далай ламтай удаан ярилцаж, түүнд Цагаан хааны бэлгийг өөрийн биеэр гардуулан өгсөн ажээ. Ар Монголтой холбоотой Оросын Засгийн газрын тусгай зааврын талаар юм мэдэгдээгүй.

Харин 1908 онд Бээжин хотноо Д.Д.Покотиловын халааг авсан Коростовецын хувьд байдал өөр байлаа. Засгийн газраас нь түүнд өгсөн заавруудад, Манж Чин улсад “Манай эрх ашгийг Баруун Европынхтой адилтгаж болохгүй”, харин “1898 оныг хүртэл (хэрэгжүүлж байсан)

¹⁶ № 17, 1881 г., февраля 12, С.-Петербургский Договор между Россией и Китаем об Илийском крае и торговле в Западном Китае. *Русско-Китайские Отношения 1689-1916*. Москва, 1958, 57.

¹⁷ Мөн тэнд, 54-60.

¹⁸ А.Н.Хохлов, Д.Покотилов. *Вопросы Истории* 5 (2011), 36-54.

бодлогыг үргэлжлүүлэх, өөрөөр хэлбэл энх тайвнаар, бусад улс орноос тусдаа үйл ажиллагаа явуулах"-ыг чармайх хэрэгтэй гэсэн байдаг.¹⁹ Японтой нөлөөллийнхөө хүрээг тогтоон тодорхойлох нь Оросын гадаад бодлогод маш чухал ач холбогдолтой болохыг заавруудад онцолсон буй. Оросын Засгийн газар "Монголын талаарх бидний байр суурь" "хамгийн чухал асуудлуудын нэг" хэмээн онцолсон ч, уг баримт бичигт бас "одоогийн энэ цаг үеийг юутай ч Монголд идэвхтэй бодлого явуулахад тохиромжтой биш гэж үзэх ёстой" гэсэн байх ажээ.²⁰ Тиймээс Засгийн газар нь Коростовецэд монголчуудтай эдийн засаг, соёлын харилцаагаа бэхжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлэх зааврыг өгсөн буй. Монголчуудад зориулан сургууль барьж, "Манай их дээд сургуулиудад монгол залуучуудыг элсүүлэх", заавруудад дурьдсанчлан "Орос улсад онцгой их итгэл хүлээлгэж, туйлын талтай байдаг" Далай ламтай найрсгаар харилцахад санаа тавихыг Засгийн газар нь түүнд зөвлөмж болгож байжээ.²¹

Эцэст нь Орос-Японы 1910 оны 7-р сарын 4-ний өдрийн гэрээ Франкийн хэлснээр "Зүүн Азийн улс төрд жинхэнэ эргэлт"-ийг авчирсан юм. Түүнээс хэдхэн долоо хоногийн дараа Солонгосын эзэн хаан Японы эзэн хаанд "Солонгос улсын бүх нутаг дэвсгэрийг захирах өөрийн бүрэн эрхийг тэр чигт нь бүрмөсөн, үүрд" шилжүүлсэн байна.²² Ингээд "Солонгосын асуудал" Японы талд ашигтайгаар шийдэгдэв.

Ингээд Оросын Гадаад хэргийн яам "Монголын асуудал"-аар өөрийн хүсэл зорилгыг гүйцэлдүүлэх ажлыг урагш нь ахиулах цаг боллоо гэж үзэв. Тус яам "Монгол дахь статус квог өөрчлөхгүй, тэнд цэргийн арга хэмжээ авахгүй байх үүргийг Хятадаар хүлээлгэх"-ийн тулд тус улсад ямар байдлаар дарамт шахалт үзүүлэх талаар төлөвлөгөө боловсруулах үүргийг Бээжин дэх өөрийн элч төлөөлөгч И.Я.Коростовецэд өгсөн байна.²³ Гадаад хэргийн сайд Сазонов "Бүх асуудал... Хятадтай харилцах манай харилцааны гол цөмийг хөндөх" бөгөөд "бусад улс гүрэн, гол нь Англи, Японтой урьдчилан хийх зөвшилцөл"-өөс хэрэгжилт нь хамаарна хэмээн ажилтнууддаа сануулсан буй.²⁴ Сазонов 1910 оны 12-р сарын 10-нд Токио дахь элчин сайддаа "Солонгосыг албадан хавсаргахдаа бидэнд өгсөн амлалтын биелэлтийг Японоос шаардах мөч ирлээ" хэмээн мэдэгджээ.²⁵ Ингээд Орос улс "Монголын асуудал"-ыг идэвхтэй авч үзэж эхэлсэн, тэгэх шалтгаан ч хангалттай байсан. Хятадын худалдаа Ар Монголоос оросын худалдааг шахан гаргах аюул нүүрлээд байв. Нөгөөтэйгүүр, энэ бүс нутагт Хятадын цэргийн ажиллагаа идэвхжиж байгааг анзаарахгүй байхын аргагүй

¹⁹ А.Н.Хохлов. *Российский дипломат И.Я. Коростовец и его роль в подготовке Цицикарского протокола 1911 г.*, in www.synologia.ru

²⁰ Мөн тэнд.

²¹ Мөн тэнд.

²² O.Franke. *Die Großmächte in Ostasien von 1894 bis 1914. Ein Beitrag zur Vorgeschichte eines Krieges.* Braunschweig und Hamburg, 1923, 333.

²³ B. von Siebert. *Diplomatische Aktenstücke zur Geschichte der Entente politik der Vorkriegsjahre.* Band I, Berlin und Leipzig, 1921, 271.

²⁴ Мөн тэнд.

²⁵ Мөн тэнд, 276.

болжээ. Оросын Гадаад хэргийн яам арван жил тутам шинэчилдэг Петербургийн гэрээний (1881) хугацаа дууссаныг далим болгон “Монголын асуудал”-ыг шийдвэрлэх шаардлагыг Манж Чин улсын Засгийн газарт сөргүүлэн тавив. Орос улс 1911 оны 2-р сарын 16-ны өдрийн ноот бичигтээ 1881 оны Петербургийн гэрээг зөрчсөн хэмээн Манж Чин улсыг буруутгаж, Монголтой нягт холбоо бүхий зургаан зүйл шаардлагыг тавьсан байна.²⁶

Гэвч удалгүй 1911 оны 10-р сарын 10-нд Вучанд гарсан цэргийн үймээний улмаас Орос улс үйл ажиллагаа явуулах шахаанд оржээ. Чингийн ноёрхол асар хурдан суларч байлаа. Манжийн сүүлчийн эзэн хаан Пү-и 1912 оны 2-р сарын 12-ны өдөр ширээнээсээ буув. Түүнээс нэг сарын өмнө монгол ноёд Халх-Монголын шашны тэргүүн Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанд өргөмжлөөд байв. Оросын Гадаад хэргийн яам өөрийн дипломатч И.Я.Коростовецэд Монгол улсын шинэ Засгийн газартай хэлэлцээ хийж, гэрээ байгуулах үүрэг өгч, түүнийг 1912 оны 9-р сард Монголд илгээв. Гэрээг 1912 оны 10-р сарын 21-ний өдөр байгуулсан байна. Түүгээр Орос улсын Засгийн газар “өөрийн байгуулсан автономит дэглэм”-ийг хадгалахад нь Монгол Улсад туслах үүрэг хүлээсэн юм. Бусад улс гүрний ашиг сонирхол, “нээлттэй хаалганы зарчим”-ыг харгалзан үзэх зайлшгүй шаардлага талаас нь цэгнэж үзэхүйд, тэр тусмаа бүрэн эрхийн талаар нэг ч үг унагаагүйг бодоход энэ нь чухам ухаалаг шийдэл байсан мэт. Мөн өдөр байгуулсан нэмэлт протоколд Орос улс 1881 оны Петербургийн гэрээний зохицуулалтаас хамаагүй хальж гарсан давуу эрхийг өөртөө тогтоож өгчээ. Орос-Монголын 1912 оны 10-р сарын 21-ний өдрийн хэлэлцээр байгуулагдсанаар “Монголын асуудал”-ыг шийдвэрлэх эхний (бас хамгийн чухал) шат дууссан. Оросын Гадаад хэргийн яам угийн хүсэж байснаасаа илүү амжилтад хүрчээ. Бусад улс гүрэн энэ шийдэлд ямар хариу үйлдэл үзүүлэхийг үнэндээ үнэлж дүгнэж чадаагүй ч гэсэн тэр амжилтад хүрсэн. Орос улс дахиад урьдаас таахын аргагүй улс төрийн хямралд унах аюул нүүрлэсэн Европт анхаарлаа илүүтэй хандуулах хэрэгтэй болов. Ингээд “Монголын асуудал”-аас түр амсхийх болсон, тэгээд ч Бээжин болон Хятадад ноёрхлын харьцаа цаашид хэрхэхийг урьдчилан тааварлах аргагүй байсан билээ.

Германы Гадаад хэргийн яамны тайлан мэдээнүүдэд “Монголын асуудал” туссан нь

Германы Гадаад хэргийн яамны баримт бичгийг үндэслэн “Монголын асуудал”-ыг авч үзэх шалтгаан хангалттай бий. Судалгаанд хамруулсан хугацаанд Герман улс нь Хятадад, тэрчлэн “Зүүн Азийн асуудал”-аар харьцангуй шинэ тоглогчид тооцогдож байв. Франке “Герман улс худалдаа, усан тээврийн гэрээнүүдээр нь олгогдсон эрхээс өөр эзэмшсэн юу ч үгүй, боомтуудад өөрийн

²⁶ Оросын тавьсан шаардлагууд: Өөрийн гаалийн тарифтай байх. Оросын харъяат албатууд Монголд Оросын хуулинд захирагдаж, тэнд чөлөөтэй амьдарч, аялж, худалдаа наймаа хийж, Оросын Консулын газар буй газруудад газар худалдаж авах эрх эдлэх. Орос улс одоогийн Консулын газруудынхаа зэрэгцээ Ховдод ч бас Консулын газраа ажиллуулж болно. Оросын Консулын газруудыг Хятадын засаг захиргаа хүлээн зөвшөөрч, зохих ёсоор харилцаж байна.

гэсэн салбаргүй, эзэмшил газар ч үгүй, улс төрийн боломжийг ашиглах ямар нэг түшиц газаргүй, тэр ч байтугай тогтсон төлөвлөгөө юм уу, удирдамж болохуйц санаа оноо улсынх нь төв албанд байгаа эсэх нь ч үл мэдэгдэнэ” хэмээн бичсэн буй.²⁷ АНУ-ын нэгэн адил Герман улс ч бас Хятадад юуны өмнө худалдаа, аж үйлдвэртээ борлуулалтын зах зээл хайж байв. Тиймээс Герман улс юуны өмнө эдийн засгийн ашиг сонирхлыг мөрдлөг болгон, Хятад дахь “нээлттэй хаалганы зарчим”-ыг дэмжиж байгаагаа удаа дараа онцолж байсан юм. Герман улс нь АНУ-ын нэгэн адил Хятад улсын нутаг дэвсгэр, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалахын төлөө байгаагаа илэрхийлж байсан тул Чин улсын Засгийн газар, хожим нь Юань Шикайн Засгийн газартай сайн харилцаатай байсан. Тийм ч учраас Герман улс Зүүн Ази болон Хятадад болж буй үйл явдлуудыг нэлээд төвийг сахисан, бодитой, бас айвуу тайвуу гадны нүдээр харж байсан билээ.

“Монголын асуудал”-ыг хамарсан “Зүүн Азийн асуудал”-ын талаарх мэдээллийг Германы Гадаад хэргийн яам (Auswärtiges Amt) үндсэндээ дараах хоёр чиглэлээр авч байсан мэт:

1. Токио, Бээжин, Лондон, Петербург, Вашингтон дахь дипломат төлөөлөгчийн газруудын тайлан. “Монголын асуудал”-аарх олон чухал баримт бичгийг 1926 онд “Европын кабинетуудын их улс төр”²⁸ баримт бичгийн цуглуулгад нийтэлсэн буй. Өнөө хэр нягталж үзээгүй байгаа өөр олон баримт материал Гадаад хэргийн яамны архивт байж байна.

2. Оросоос хууль бусаар авсан нууц мэдээллүүд. Жишээ нь, Гадаад хэргийн яам 1909 оны 3-р сараас 1914 оны 7-р сарыг хүртэл Лондон дахь Оросын Эзэн хааны элчин сайдын яамны 2-р нарийн бичгийн дарга Бенно А. фон Зийбертээс (Benno Alexandrowitsch von Siebert) 5-6 мянга орчим нууц баримт бичгийг хүлээн авсан агаад тэдгээр баримт бичиг тус яаманд Оросын гадаад бодлогын талаар гүн гүнзгий ойлголт төсөөллийг өгч байжээ. Түүнчлэн фон Зийбертийн ажлыг зөвхөн Рейхийн канцлер, Гадаад хэргийн яаманд бол төрийн нарийн бичгийн дарга, түүний орлогч, улс төрийн хэлтсийн дарга, орос хэлний орчуулагч л мэддэг байсан нь түүний тагнуулын үйл ажиллагааны ач холбогдлыг илтгэн харуулна.²⁹ Б.А. фон Зийберт өөрөө эдгээр баримт бичгийн гол хэсгийг 1920-иад онд Берлинд хоёр эмхэтгэл болгон хэвлүүлсэн байна.³⁰

²⁷ O. Franke. *Die Großmächte in Ostasien von 1894 bis 1914. Ein Beitrag zur Vorgeschichte eines Krieges*. Braunschweig und Hamburg, 1923, 27.

²⁸ Die Große Politik der Europäischen Kabinette 1871-1914. *Sammlung der Diplomatischen Akten des Auswärtigen Amtes*, Bd. 32, *Die Mächte und Ostasien 1909-1914*. Berlin 1926 (=GPdEK-32)

²⁹ Stephen Schröder. “Ausgedehnte Spionage” Benno von Sieberts geheime Zusammenarbeit mit dem Auswärtigen Amt (1909-1926), in *Militärgeschichtliche Zeitschrift MGZ* 64(2005), 430.

³⁰ B. von Siebert. *Diplomatische Aktenstücke zur Geschichte der Entente-politik der Vorkriegsjahre*. Band I, II, Berlin und Leipzig 1921 (=B. v. Siebert, I.). Тэр үед Берлинд мөн бидний сайн мэдэх Иван Я. Коростовец, бас 1912-1917 онд Оросын Гадаад хэргийн яаманд гадаад хэргийн гурван сайдын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Владимир Коростовец нар амьдарч байжээ. Тэдгээр нь фон Зийберттэй хэр холбоотой байсан нь мэдэгдэхгүй байна.

Хятадад их гүрнүүдийн юу хийж байгааг Гадаад хэргийн яам болон Германы элчин сайдын яамд маш хянамгай ажиглаж байв. Зөвхөн Оросын талаарх Их Британийн бодлогоос л гэхэд Европ дахь хүчний тэнцвэрийн талаар чухал дүгнэлт хийж болж байв. Оросын улс төр, тэр бүү хэл тус улсын нөөцийг (цэрэг, эдийн засгийн г.м) Зүүн Азитай илүү нягт холбож байсан тэр бүх зүйл Европ дахь Оросын идэвх оролцоонд нөлөө үзүүлсэн байж болох талтай.

Дүгнэлт хийхэд шаардлагатай, их төлөв Рейхийн Канцлерт шууд хандсан үндсэн мэдээллийг Токио дахь элчин сайд болон Бээжин дэх элч төлөөлөгч нь өгч байв. Хэрвээ хүлээн авсан орных нь үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр, эсвэл өндөр албан тушаалтнуудтай хийсэн ярилцлагуудаас холбогдох учиг сэжүүр гарч ирвэл Лондон, Санкт Петербург, Вашингтон дахь Германы элчин сайдууд ч бас Берлинд мэдээлдэг байв. Мөн Токио, Бээжингээс ирсэн тодорхой мэдээллийг суугаа орнууддаа шууд бусаар шалгаж үзэх зааврыг Гадаад хэргийн яам зарим үед тэдгээр элчин сайдад өгч байжээ. Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нь эзэн хаан буюу түүний холбогдох албатуудад шууд мэдээлдэг байв. Улс орны талаар дүгнэлт гаргахдаа дурдсан хоёр чиглэлээр ирсэн мэдээллийг хоёуланг нь авч үзэж байсан нь мэдээж. Өөрөөр хэлбэл “Монголын асуудал”-аар Гадаад хэргийн яамны жинхэнэ мэдэж авч байсан зүйл нь зарим талаар элчин сайдын яамдын тайлан мэдээг уншиж мэдсэнээс нь ч илүү гүн гүнзгий мэдээллийг өгч байсан хэрэг.

Тэгэхлээр Герман улс “Монголын асуудал”-ын талаар юу мэдэж, үүнд хэрхэн хандаж байв? Ингэхдээ надад байгаа баримт бичгүүдийн цуглуулга дахь баримтуудыг үндэслэн давын өмнө “Монголын асуудал”-аарх нэмэлт мэдээллийг л он дарааллаар нь танилцуулах боломжтой байгааг минь бодолцоосой гэмээр байна. Тайлбар, дүгнэлтийг Гадаад хэргийн яамны Улс төрийн архивт байгаа баримт бичгүүдийг судалж үзсэний дараа болох нь зүйтэй болов уу.

Германы Гадаад хэргийн яамны “Монголын асуудал”-ын талаарх мэдээлэл

Надад мэдэгдэж байгаа баримт бичгүүдээс үзэхэд “Монголын асуудал” Гадаад хэргийн яамны анхаарлын төвд 1910 оноос илүүтэй их орох болсон байна. Үүний шалтгаан нь Орос, Япон хоёр улс 1907 оны 7-р сарын 30-нд гэрээ байгуулж ойртсон явдал юм. Гэрээ нь нууц заалтуудтай байж, түүгээр “Монголд онцгой эрх эдлэх Орос улсын байр суурь зэргийг Японы талаас хүлээн зөвшөөрсөн”³¹ гэж Гадаад хэргийн яам таамаглаж байв. Хятадын зах зээлд Германы эдийн засгийн чөлөөтэй үйл ажиллагаа явуулах боломжийг Орос, Япон улсууд хязгаарлаж болох байсан тул уг хоёр гүрний ойртсон явдал Гадаад хэргийн яамны Зүүн Азийн бодлогод ихээхэн учир холбогдолтой байсан.

Баримт бичгүүд дээр зах хөвөөгөөр нь гараар бичсэн тэмдэглэлүүдээс үзэхэд эзэн хаан II Вильхелм (Wilhelm II) тайлан мэдээнүүдийн нэг хэсгийг байнга

³¹ Nr. 11703, Der Botschafter in Tokio Freiherr Mumm von Schwarzenstein an den Reichskanzler von Bethmann Hollweg, 6. Mai 1910, *GPdEK*-32, 116.

уншдаг байжээ. Тэрээр 1910 онд “Монголын асуудал”-тай байн байн тулгарч байсныг бид энэ маягаар олж мэднэ. Тухайлбал Орос, Япон улсууд удахгүй Манжуурын статус квог гэрээгээр тохиролцох гэж байгааг *Daily Telegraph* Санкт Петербургээс мэдэгдсэн тухай Лондонд сууж байсан элчин сайд 1910 оны 6-р сарын 24-нд мэдээлсэн байдаг. Үүнтэй холбогдуулан эзэн хаан II Вильхелм “Хятадад алдагдалтайгаар Манжийг Японоос, Монголыг Оросоос салгаж авах хэрэгтэй... хэрэв Америк, Японы хооронд мөргөлдөөн гарвал...” хэмээн тэмдэглээд, “Азид Орос улс Японд... дэмжлэг үзүүлэх шахаанд орвол, бусдаар бол Владивостокийг алдана, Монгол, Зүүн Сибирийг ч бас”³² гэж дүгнэсэн буй. Манжуур, Монголын тухайд тэр Япон, Орос улсууд Манжуур, Монголыг бусад улсад хаалттай болгож, Хятадаас салган бутаргаж, “нээлттэй хаалганы зарчим”-аас ухрах вий хэмээн эмээж байж.

Гэхдээ хоёр гүрэн Хятадтай гэрээний дагуу зохицуулалт хийх шаардлагатай байсан. Тиймээс Манж Чин улсын Засгийн газар 1881 оны Петербургийн гэрээг шинэчлэхийг хүссэн нь Оросын хувьд онц сонирхолтой байв. Петербургийн гэрээний ашиг тусыг хүртэх Оросын эдийн засгийн чадавхи хангалтгүйн улмаас тус улс ацан шалаанд ороод байсныг Гадаад хэргийн яам 1910 оны 7-р сарын “Зийбертийн баримт бичиг”-ээс олж мэджээ. Тиймээс шаардлагаа хэрэгжүүлэхийн тулд Хятадад хэрхэн дарамт шахалт үзүүлэх талаар ярьж хэлэлцэхэд цэргийн арга хэмжээг болгоомжтой хэрэглэхэд болохгүй гэх газаргүй гэж Орос үзэж байж.

Эзэн хаан II Вильхелм 1910-оны 7-р сарын дундуур хамгийн ойрын зөвлөхүүдийнхээ хүрээнд Орос, Японы гэрээний талаар дахин ярилцсан байна. Эзэн хаан Орос, Японы нутаг дэвсгэрийн санаархалд “ирээдүйн төлөө тээг тавих” санаатай байгаа гэж түүний ойрын хүрээллээс дууджээ. Герман улс АНУ-тай ижил санаа бодолтой байгааг тэр онцолж байв. “Монголыг нэгтгэх” нь Янцзегийн (Jangtse) гэрээг зөрчиж буй хэрэг гэж эзэн хаан үзэж буй бөгөөд тэр тохиолдолд Британийн ашиг сонирхолд ч аюул заналхийлэх болно гэж протоколд тэмдэглэсэн буй. Хэд хоногийн дараа Рейхийн канцлер эзэн хаан II Вильхелмд ханджээ. Тэр түүнд Санкт Петербург, Япон хоорондын гэрээний бүрэлдэхүүн хэсэг нь зөвхөн Манжуур болохыг мэдэгдсэн байна. Алс Дорнод дахь Оросын оролцоо улс төрийн хувьд л зөв зүйтэй байна уу гэхээс энэ маягаараа бол Орос улс “Японы хилийн хөрш болж, улмаар ирээдүйд ноцтой толхилцоонд хүргэж мэднэ”³³ хэмээжээ. Англи Оросыг Германы эсрэг санаа зорилготойгоор нэгтгэсэн шиг Герман улс Оросыг хүчээ Алс Дорнодод байлгаж байхыг сонирхож байв. Нарийндаа яривал энэ нь Дэлхийн I дайнд хүрэх замыг зассан тоглолт байсан билээ.

Гадаад хэргийн яам Оросын Сайд нарын Зөвлөлийн нэгэн хурлаар яригдсан дотоод асуудлын талаар 1910 оны 11-р сарын “Зийбертийн баримт бичиг”-ээс мэдэж авсан байна. Орос улс Японтой гэрээ байгуулснаар илүү баталгаатай

³² Nr. 11704, Der Botschafter in London Graf von Metternich an den Reichskanzler von Bethmann Hollweg, 24. Juni 1910, *GPdEK*-32, 118.

³³ Nr. 11709, Der Reichskanzler von Bethmann Hollweg, z.Z. in Hohenfinow, an Kaiser Wilhelm II., z.Z. in Bergen, 16. Juli 1910, *GPdEK*-32, 125.

боллоо гэж үзэх болсон ажээ. Японы зүгээс заналхийлэх аюул алга байв. Бас Япон-Хятадын холбоо бий болохоос сэрэмжлэх ч хэрэггүй болжээ. Эрхүү болон Амурын бүс нутгийн цэргийн тойргууд дахь 29.000 хүний бүрэлдэхүүнтэй хилийн цэргийн корпус нь ганц Хятадын эсрэг гэхэд л хангалттай хүч байв. Сайд нарын Зөвлөл Хятад дахь Оросын гэрээний эрхийг “бүхий л хүчээрээ” хамгаалах, шаардлагатай бол консулуудаа “албан хүчээр томилж ажиллуулах”-ыг шаардаж байв. Хурлын протоколд “Биднийг өөрсдийн эрхийг ухамсарлан эрс хатуу шаардлага тавих бүрийд Хятад бууж өгдгийг туршлага харуулсан”³⁴ гэсэн байлаа. Оросын Сайд нарын Зөвлөл зардал, олон улсад ээдрээ түвэгтэй байдал үүсэх, хүн амаа дургүйцэх вий гэсэндээ “Хятадаас нэг муж тасдаж авах”-аас татгалзсан байна. Орос улсад Монголын талаар ч бас баримтлах олон талаас нь иж бүрэн бодож боловсруулсан үзэл баримтлал хэрэгтэй болохыг тэдгээр хүчин зүйлс харуулжээ.

Гадаад хэргийн яам өөр нэг “Зийбертийн баримт бичиг”-ээс Токиод сууж байсан Оросын элчин сайдын Японы Гадаад хэргийн сайд Комуратай хийсэн ярилцлагын талаар мэдэж авчээ. Комура Хятадад үзүүлэх шахалтаа хэтрүүлэхгүй байхыг зөвлөсөн аж. “Чухамдаа Хятадын сул тал л аюултай”, шахалт үзүүлбэл Хятадыг “Америк, Германы гарт аваачаад хийчихэж мэднэ”, тэгэх аваас тэд “Бээжинд материаллаг ашигтай байдал, давуу талаа баталгаажуулах”³⁵ боломжтой болно гэсэн байна.

Санкт Петербургт сууж байсан элчин сайд Граф фон Портуалес Оросын гадаад хэргийн сайд Сазоновтой уулзсан талаараа 1911 оны 2-р сарын 16-нд Рейхийн Канцлерт мэдээлсэн бөгөөд тэрхүү уулзалтаар Сазонов түүнд “Орос, Хятадын хооронд үүссэн ялгааны тухай бичиг”-ийг нууцаар танилцуулсан ажээ. Түүндээ Орос улс “хоёр орны худалдаанд гаалийн татвар ногдуулах”, Оросын харъяат албатууд Хятад, ялангуяа Монгол болон Баруун Хятадад оршин суухдаа дотоодынх нь хуульд үл захирагдах, Оросын харъяат албатууд суурьших эрх эдэлж, “татваргүй, монополоос чөлөөтэй ямар ч гарал үүсэл бүхий бүх төрлийн бүтээгдэхүүнээр наймаа худалдаа хийх, Ховд, Суми, Гучэнд консулуудаа томилоход Хятадын Засгийн газар зөвшөөрлөө өгөхөөс татгалзахгүй байх” зэрэг шаардлагыг тавьсан байна. Оросын консул суугаа хотуудад Оросын харъяат албатуудад газар авч, дээр нь байшин барих эрх олгохыг шаардсан нь туйлын их гайхшруулсан эмзэг асуудал байлаа. Хэрэв Хятадын тал Оросын шаардлагыг зөвшөөрөхгүй бол Орос улс тус улсын хил дээр цэргийн сүр хүчийг үзүүлэх багахан хэмжээний арга хэмжээ зохион байгуулах бодолтой байгааг Сазонов Германы элчин сайдад хэлжээ.³⁶

³⁴ Protokoll einer besonderen Ministerratssitzung in Petersburg vom 19. November/2. Dezember 1910, *B. v. Siebert. I*, 274-275.

³⁵ Telegramm des russischen Botschafters in Tokio an den russischen Außenminister vom 4./17. Dezember 1910, Nr. 206, Мөн тэнд, 276-277.

³⁶ Nr.11790, Der Botschafter in Petersburg Graf von Pourtalès an den Reichskanzler von Bethmann Hollweg, St. Petersburg den 16. Februar 1911, 214-215.

Орос улс Хятадад шаардлага тавихаа арай багасгав. Петербургийн гэрээгээр баталгаажуулсан эрхүүд, “тухайлбал Хятадад их хэрмийн цаана болон Монголд чөлөөтэй худалдаа хийх, Оросын харьяат иргэд дотоодынх нь шүүх, засаг захиргааны хууль журамд захирагдахгүй байх, манай консулын газруудыг Ховд, Хами, Гүчэнд байгуулах”³⁷-ыг Бээжингийн Засгийн газар хүлээн зөвшөөрөх асуудал тавигдаад байгааг гадаад хэргийн сайд Сазонов Парис, Лондон, Токио дахь элчин сайд нартаа уламжилжээ.

1881 оны Петербургийн гэрээг шинэчлэх асуудал Санкт Петербургт хүмүүсийг сандралд оруулав. Түүгээр “Зүүн Азийн асуудал”-тай холбоотой чухал шийдвэр гарна гэж Цагаан хаан үзэж байсан тул дайны болон гадаад хэргийн сайд нартайгаа өдөр бүр хуралдаж байгаа тухай нууц мэдээллийг Венад сууж байсан Германы элчин сайд 1911 оны 2-р сарын 20-нд уламжилсан байна. Тэр үед гадаад хэргийн сайд Сазонов Зүүн Азитай холбоотой орос цэргийнхнийг “тэндээс армидаа хямдхан ялалт авчирна гэж итгэж байх шиг тул дайтах гэж их хорхойсч байна”³⁸ гэж байжээ. Сазонов “Хятадтай хиллэдэг манай хил” дээр “цэргийн зарим арга хэмжээ” авахын төлөө байгаагаа илэрхийлсэн ч “тэр нь манай армийн бүх хүчийг дайчилж, биднийг Европод тавьсан зорилтуудаас маань бүрмөсөн хөндийрүүлэх хэмжээнд хүргэж болохгүй”³⁹ гэжээ. Шалтгаан нь тодорхой байлаа. Сазонов “Европод эрх мэдлийн томоохон асуудлууд эн тэргүүнд тавигдаад байгаа”-г анхааруулжээ. Тэр “Эрх мэдлийн ихээхэн өөрчлөлт гарах шинж илэрч байна...” хэмээн онцолсон байна. Орос улс Гурвалсан холбоо (Dreibund) болон Гурвалсан Антантыг (Triple Entente) зөнд нь орхиж болохгүй гэсэн шаардлагыг тэр тавьж байсан.⁴⁰

Оросын Гадаад хэргийн яам 1910 оны 12-р сараас эхлэн тулган шаардах бичгээр Манж Чин Улсын Засгийн газарт шахалт үзүүлж эхлэв. Гэвч тус Засгийн газар эхний тулган шаардах бичигт хариу өгсөнгүй. Сазонов өвчилсөн тул гадаад бодлогыг удирдан явуулах болсон ерөнхий сайд Столыпин Германы элчин сайдад “Орос-Японы дайнаас хойш хятадууд Оросыг сул дорой хэмээн, юу ч хийж болно гэж үзэх болсон бололтой. Энэ байдлыг таслан зогсоох ёстой”⁴¹ гэж хэлж байжээ.

Санкт Петербургт сууж байсан Германы элчин сайд 1912 оны 1-р сарын 4-нд гадаад хэргийн сайд Сазоновтой шинээр уулзалт хийсэн тухайгаа мэдээлжээ. Сазонов Хятадад одоо хаант засаг бүрмөсөн ялагдсан гэж үзэж байв. Хятадад тусгаар тогтнох гэсэн хүсэл эрмэлзэл илэрч байгаа талаар хоёул санал бодлоо солилцжээ. Сазонов “Монголын хойд хэсэг”-ийн талаар яриа өрнүүлсэн аж. Тэр Монголыг, ядахдаа хойд хэсгийг нь Оросын эзэнт гүрэнд нэгтгэх монгол ноёдын хүсэлтийн талаар ярьсан байна. Сазоновын хэлснээр Орос улс тэрхүү

³⁷ *Der Diplomatische Schriftwechsel Iswolskis 1911-1914*. Band I, Berlin 1924, 27.

³⁸ Nr. 11792, Der Botschafter in Wien von Tschirschky an den Reichskanzler von Bethmann Hollweg, 20. Februar 1911 Botschafter in Wien an den Reichskanzler, *GPdEK*-32, 216.

³⁹ Мөн тэнд, 217.

⁴⁰ Мөн тэнд, 217.

⁴¹ Nr. 11796, Der Botschafter in Petersburg Graf von Pourtalés an den Reichskanzler von Bethmann Hollweg, 1. April 1911, *GPdEK*-32, 220.

гуйлт хүсэлтийг хүлээж авахаас ямагт татгалзаж ирсэн аж. Харин сүүлийн үед Монголын шинэ төлөөлөгчид Цагаан хаанд өргөх бичиг хүргэж ирснийг тэр хэлжээ. Оросын Эзэнт гүрэнд нэгдэх байна уу, Оросын ивээл хамгаалалд багтах байна уу, аль нь ч байлаа гэсэн “Хятадын үймээн буужигнаан”-ы улмаас, дээр нь бас Оросод санхүүгийн шинэ дарамт үүсэх учраас Засгийн газар татгалзсан юм гэсэн аж. Сазонов “Монгол орон тусгаар тогтнолоо зарлаж, Орос, Хятадын дундах жийргэвч улс болох нь Оросын ашиг сонирхолд нийцнэ”⁴² хэмээн мэдэгдсэн байна. Уг баримт бичгийн энэ хэсэгт эзэн хаан II Вильхелм “Утгагүй юм. Тэд тэднийг авах ёстой, эс бөгөөс япончууд хүрч ирнэ!”⁴³ хэмээн захад нь тэмдэглэсэн байх ажээ.

Их гүрнүүд Чин улсын хаант засаг огцорч, Юань Шикай засгийн эрх авахыг хүлээж байсныг “Зийбертийн баримт бичиг”-т орсон Оросын гадаад хэргийн сайдын 1912 оны 1-р сарын 10-ны өдрийн санамж бичиг харуулна. Их гүрнүүд “Хятадад гадаадын иргэдийн эрхийг баталгаажуулахаас хамааралтайгаар”⁴⁴ тус улсыг хүлээн зөвшөөрөх тал дээр санал нэгтэй байсан бололтой. Тэр нөхцөлд Орос улс 1-т Манжуур дахь ашиг сонирхол, 2-т 1881 оны Петербургийн гэрээг шинэчлэн засварлах асуудалд анхаарлаа хандуулж байв. Үүнтэй холбогдуулан Сазонов “Монголын асуудлын цаашдын чиг хандлагын талаар, тус улс цаашид Хятадын эзэнт гүрний автономит эрхтэй бүрэлдэхүүн хэсэг байна гэсэн утгаар”⁴⁵ ярьж байж. “Хятад улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалах зарчимд шууд харшлах улс төрийн ашиг сонирхлоо бид нягталж үзэх ёстой”⁴⁶ тул Монголын асуудлыг шийдвэрлэхээ хойшлуулах шаардлагатай гэж Гадаад хэргийн сайд үзсэн. Энэ болон бусад мэдэгдлүүдээс нь харахад Оросын Гадаад хэргийн яам нээлттэй хаалганы зарчмыг хадгалж, улмаар Хятад улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэн үзэхийн хамтаар “Монголын асуудал”-ыг шийдвэрлэхийг улам бүр сонирхох болсон байна.

Тус яам Хятадын үндэсний эрх ашгийг хүндэтгэн үзсэндээ ч тэгсэн бус, бусад их гүрэнтэй л Хятадад зөрчилдөхийг хүсэхгүй байсан хэрэг. Тэр ч үүднээс Оросын Гадаад хэргийн яам Түвдийн асуудлаар Түвд болон Хятадын Засгийн газар, тэрчлэн Хятад болон Түвдтэй хэлэлцээ хийж байсан Их Британийн алхам нэг бүрийг маш анхааралтай ажиглаж байлаа.

Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн даргын орлогч 1912 оны 1-р сарын 24-нд Рейхийн канцлерт мэдээлэхдээ: “Өнөөг хүртэл бүх улс гүрэн Хятад улсын бүрэн эрхт, бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж, нээлттэй хаалгыг бүгдэд хадгалж байх талаар удаа дараа гаргасан мэдэгдэлдээ үнэнч байж, тус улсын дотоод хэрэгт оролцолгүй хол байж ирэв... Гэтэл олны танил эх сурвалжаас авсан мэдээнд дурьдсанаар Орос улс Монгол дахь Хятадын бүрэн эрхийг албан ёсоор

⁴² Nr. 11812, Botschafter in Petersburg Graf von Pourtalés an den Reichskanzler von Bethmann Hollweg, 4. Januar 1912, *GPdEK*-32, 246.

⁴³ Мөн тэнд, 246.

⁴⁴ Memorandum des russischen Außenministers vom 10. (23.) Januar 1912, *B. v. Siebert*, I, 282.

⁴⁵ Мөн тэнд, 284.

⁴⁶ Мөн тэнд, 284.

хөндөхгүй байх, тэр бүү хэл Монгол орон тусгаар тогтнолоо тунхагласныг авч хэлэлцэлгүй алгасан дараачийн сэдэвт орохыг хүсч байна”⁴⁷ гэжээ.

Берлин дэх Оросын элчин сайдын яамны зөвлөх нэг ярилцлагаараа “Орос улс Хятадын бүрэн эрх, бүрэн бүтэн байдлыг алдагдуулах гээгүй, Монголд Хятадын давуу эрхийг хадгалахын сацуу гагцхүү Бээжинтэй зөвшилцсөний үндсэн дээр эдийн засгийн асуудлуудыг зохицуулах хүсэлтэй”⁴⁸ байгааг дахин нотолсон байна.

1912 оны 5-р сарын 1-ний өдрийн “Зийбертийн баримт бичиг”-т Бээжин дэх Оросын элч төлөөлөгч гадаад хэргийн сайддаа бичихдээ, Орос улс “Умард Манжуур, Монгол, Баруун Хятад”-ад цэргийн ажиллагаа явуулдаг юмаа гэхэд гадаад улс гүрнүүдийн зүгээс ямар нэг эсэргүүцэл үзүүлэхээргүй байна гэжээ. АНУ-ын дипломат төлөөлөгч “Түүнд буй зааварт Монгол, Манжуур дахь манай үйл ажиллагааг таслан зогсооход хүргэж болзошгүй зүйл огт байхгүй” хэмээн мэдэгджээ. Их Британийн төлөөлөгч батлан хэлэхдээ “Та нар одоо Баруун Хятад, Ар Монголд ямар ч эргэлзээгүй огтхон ч санаа зовох юмгүйгээр ажиллагаа явуулж болно...” гэсэн байна.⁴⁹

Орос, Япон хоёр улс Өвөр Монголыг Бээжингийн уртрагаар баруун, зүүн хоёр хэсэгт хуваасан нэмэлтийг 1907 оны 7-р сарын 17-30-ны гэрээний нууц заалтад оруулж нөлөөллийн хүрээгээ шинээр тогтоох гэж байгааг Гадаад хэргийн яам 1912 оны 6-р сарын 19-ний өдрийн “Зийбертийн баримт бичиг”-ээс мэджээ. Баруун хэсэг нь Оросын, зүүн хэсэг нь Японы нөлөөллийн хүрээ болох ёстой байв.

Өдгөөг хүртэл миний авч ашиглах боломжтой байсан Гадаад хэргийн яамны мэдээллүүд тус яам Коростовецын Монголд хийсэн хэлэлцээний тухай юу мэдэж байсан талаар хэрэгтэй мэдээ өгөхгүй байна. Ямар нэг зүйлийг Гадаад хэргийн яам мэдэж байсан нь лав, архиваас нь олдох ч болов уу. Тэрчлэн Германы “аялагч” Херманн Констен (Hermann Consten) 1912 онд Ар Монголд ажиллаж байсан нь тийм ч санамсаргүй явдал биш байсан болов уу, юутай ч Өргөөнд тэр Коростовецтой байсхийгээд л санаандгүй тааралддаг байсан аж.⁵⁰

Оросын дипломат төлөөлөгчийн газраас 11-р сарын 9-нд *Journal de Pèkin*-д нийтлүүлсэн Орос-Монголын хэлэлцээрийн бичвэрийг Бээжин дэх Германы элч төлөөлөгч 1912 оны 11-р сарын 11-нд Гадаад хэргийн яамандаа илгээсэн байна. Онцгой тохиолдолд Орос улс Ар Монголыг зэвсгийн хүчээр ч гэсэн хамгаалах болно гэж Оросын элч төлөөлөгч түүнд бас батлан хэлсэн ажээ.

Орос-Монголын хэлэлцээрийн талаар гадаад хэргийн сайд Сазоновтай ярилцсан тухайгаа Германы хэргийг түр хамаарагч 1912 оны 12-р сарын 25-нд мэдээлжээ. Тэр ярилцлагаар хэргийг түр хамаарагч Оросын уг хэлэлцээрийг

⁴⁷ S. 11818, Aufzeichnung des stellvertretenden Staatssekretärs des Auswärtigen Amtes Zimmermann für den Reichskanzler von Bethmann Hollweg, 24. Januar 1912, *GPdEK*-32, 251.

⁴⁸ Мөн тэнд, 251.

⁴⁹ Bericht des russischen Gesandten in Peking an den russischen Außenminister vom 1./14. Mai 1912, in B. v. Siebert, I, 288.

⁵⁰ Үүнтэй холбогдуулан Дорис Гёттингийн туйлын гайхалтай бичсэн түүний намтар болох “Этцел” судлаач, адал явдалтан, тагнуул. Монгол судлаач Херманн Констен (1878-1957)-ы амьдралын түүх, Клаус Шварц хэвлэлийн газар, Берлин 2012, 617 хуудас зохиолыг уншихыг зөвлөх байна.

байгуулах болсон жинхэнэ учир шалтгааны талаар бага сага юм мэдэж авчээ. Тийнхүү Сазонов “Монголын амар амгалан малчин ардын оронд идэвхтэй, тайван бус хятадууд хилийн хөрш нь болохыг Орос улс ямар ч нөхцөлд тэвчиж чадахгүй”⁵¹ хэмээн мэдэгдсэн ажээ. Сазонов уг хэлэлцээрийг үндсэндээ 1881 оны Петербургийн худалдааны гэрээг шинэчилсэн хэрэг гэж үзэж байгаагаа хэлжээ. “...Угтаа монголчуудын хүссэн шиг, ивээл хамгаалал”-д авах асуудал яригдаагүй. Орос улс шинэ ачаа үүрмээргүй байна.⁵² гэсэн аж. Тэгээд Сазонов тэр хүртэл хэвлэгдээгүй байсан нэмэлт протоколын тухай ярьсан байна. Ингээд Оросын албатууд Монголд газар авах боломжтой болно гэдгийг тэр онцолсон байна. Ярианы төгсгөлд тэр Петербурgt монгол ноёдын төлөөлөгчид ирэх гэж байгааг хэлж. Эцэст нь “Тэр “ноёд”-той улс төр ярихгүй. Бэлэг, амттан л өгнө”⁵³ гэж Сазоновын хэлснийг Германы элч төлөөлөгч нямбайлан тэмдэглэж авсан байв.

Эдийн засгийн хувьд сонирхох нь бага байсан ч “Монголын асуудал”-аар байр сууриа олоход Германд хүнд байв. Хэдийгээр Орос-Монголын хэлэлцээр Германы эдийн засгийн ашиг сонирхлыг хөндөхгүй гэж Орос батлан хэлж байсан ч (Герман улс энэ тал дээр Умард Манжуурт Оростой муугүй туршлага хуримтлуулсан) Хятадад идэвх оролцоо бүхий бусад улс гүрэн шинээр бий болсон статус квог эцэс төгсгөлгүй зөвшөөрөөд байх эсэхийг Гадаад хэргийн яам хараахан баттай тогтоож чадаагүй байв. Вашингтонд сууж байсан Германы элчин сайд 1913 оны 1-р сарын эхээр Төрийн департментын төрийн нарийн бичгийн дарга Кнокстой (Кнок) ярилцсан байна. Тэрээр АНУ-д сонгууль болохоос хоёр сарын өмнө энэ асуудалд оролцохыг бодох хэн ч байхгүй, “Орос-Монголын хэлэлцээр бол тун таагүй зүйл, гэхдээ энэ тал дээр юу ч хийх арга алга”⁵⁴ гэж түүнд тодорхой ойлгуулжээ.

Германы Гадаад хэргийн яамны “Монголын асуудал”-ын талаарх дүгнэлтүүд

Гадаад хэргийн яаманд “Монголын асуудал”-д дүн шинжилгээ хийж, санал боловсруулах үйл явц 1913 оны 3-р сарын сүүлч хүртэл үргэлжилжээ. Тэгээд Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Бээжинд сууж байсан Германы элч төлөөлөгчид мэдэгдсэн нь: Монголд “юутай ч Германы худалдааны үйл ажиллагааг явуулж, цааш нь өргөжүүлэх боломж байна, тийм болохоор тэр нутагт тавьж буй Оросын онцгой хүчин чармайлтаас болж нээлттэй хаалганы зарчим алдагдахыг хүсмээргүй байна.”⁵⁵ Хятадтай 1861 оны 9-р сарын 2-нд байгуулсан худалдааны гэрээний дагуу Герман улс Монголд 1881

⁵¹ Nr. 11996, Der Geschäftsträger in Petersburg Freiherr von Lucius an den Reichkanzler von Bethmann Hollweg, 25. Dezember 1912, *GPdEK*-32, 432.

⁵² Мөн тэнд, 433.

⁵³ Мөн тэнд, 433.

⁵⁴ Nr. 11997, Der Botschafter in Washington Graf von Bernstorff an den Reichskanzler von Bethmann Hollweg, 2. Januar 1913, *GPdEK*-32, 434.

⁵⁵ Nr. 12001, Der Staatssekretär des Auswärtigen Amtes von Jagow an den Gesandten in Peking von Haxthausen, 24. März 1913, *GPdEK*-32, 438.

оны Петербургийн гэрээгээр Оросын эдэлж байсантай адил эрх эдлэх эрхтэй. “Хэрэв Хятад улс Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, өмнө жилийн 11-р сарын 3-ны протоколд дурьдсан Оросын онцгой эрхийг зөвшөөрөхөөр шийдвэл”⁵⁶ энэ боломж алдагдахаар байна гэсэн аж. Тэгээд төрийн нарийн бичгийн дарга цааш нь хэлэхдээ “Монгол оронд эдийн засгийн ашиг сонирхлоо цааш нь өргөжүүлэх боломж бүрдүүлэхийн тулд одоо мөрдөгдөж байгаа Герман-Хятадын гэрээний заалтуудыг Монгол орны хувьд үргэлжлүүлэн мөрдөх баталгаа болсон төр эрх зүйн харилцааг Монгол, Хятадын хооронд тогтоомоор байна. Үүний тулд Орос-Монголын гэрээг хүлээн зөвшөөрөхөөс цааргалж ирсэнд нь Хятадын Засгийн газарт зохистой гэсэн хэлбэрээрээ урам өгч, Монголыг Өргөөгийн хэлэлцээрийн (Орос-Монголын хэлэлцээрийг хэлжээ) үндсэн дээр олон улсын худалдаанд нээлттэй болгохыг зөвлөх нь зүйтэй болов уу. Энэ нь Хятад улс тухайлан Монголд цэргийн арга хэмжээ, засаг захиргааны үйл ажиллагаагаа тодорхой хэмжээгээр хязгаарлах, тэрчлэн колоничлолын хурдыг сааруулах замаар Оросын хүслийг бодолцож үзэхэд саад болохгүй”⁵⁷ гэжээ.

“Нээлттэй хаалганы зарчим”-ыг баримтлах угтвар нөхцөл нь Хятад улсын төрийн бүрэн эрхт, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хадгалах явдал байсан учраас Герман улс тэр үед монголчуудын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөнгүй юм. Герман улс тэр үед Монгол орны тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй ч Ар Монгол дахь Хятадын цэргийн ажиллагааны чадамж, засаг захиргааны үйл ажиллагаа, тэрчлэн Хятадын колоничлолыг хязгаарлахыг дэмжихэд бэлэн байсан мэт. Энэ нь Монгол, Хятадын харилцааны талаарх Орос-Монголын хэлэлцээрийн гол гол заалтад нийцэж байсан. Их гүрнүүдийн ашиг сонирхол, тоглолттой харьцуулахад энэ нь тийм ч бага юм биш байсан.

Герман болон бусад их гүрэн Богд Гэгээний захидлуудад яагаад хариу өгөөгүй нь одоо тодорхой болж байна. “Нээлттэй хаалганы зарчим”-ыг хүлээн зөвшөөрөх ёстой байсан болохоор тэдний байр суурь төстэй байсан болов уу. Тэр байр сууриасаа болоод Монгол улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч болохгүй байсан хэдий ч ямарваа автономит эрхийг хүлээн зөвшөөрөхийг нь хориогүй билээ. Гэхдээ улс гүрнүүд үзэл бодлоо өөрчиллөө ч гэсэн хожим монголчуудын төр улсаа хөгжүүлэх үндэс суурь чухам түүгээр тавигдсан. Орос-Монголын хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш зургаан жилийн дараа Дэлхийн I дайны эцэст АНУ-ын Ерөнхийлөгч Вудро Вильсоны 14 зүйл бүхий хөтөлбөртөө тавьсан саналуудын нэг нь улс түмнүүдийн өөртөө засан тохинох эрх байсан билээ. Орос улс ч гэсэн их гүрний хувьд тэр үед улс гүрнүүдийн зөвшилцөн тохиролцсон улаан шугамыг давж байгаагүйг Орос-Монголын хэлэлцээрийн бичвэр тодорхой харуулна.

Орос улс ч бас их гүрэн байсан, гэхдээ монголчуудтай шууд хөрш, түүхэн ойр, өмнөд хөрш Хятадаас урьдаас л болгоомжилдог байснаас ашиг сонирхол нь бусад их гүрнийхээс өөр тогтоцтой байжээ. Хэрвээ Орос улсын мөнхийн ашиг

⁵⁶ Мөн тэнд, 438.

⁵⁷ Мөн тэнд, 438.

сонирхлын нэг нь Сибирийн уудам орон зайн аюулгүй байдал байсан юм бол түүнийг хангах нэг арга зам нь монгол үндэстний төр улсын тусгаар тогтнолыг тогтоож, хадгалах явдал байсан. Тийм сонирхол Оросоос өөр ямар ч улсад байх боломжгүй байсан. Өнөөдөр ч гэсэн байдал огт өөрчлөгдөөгүй бололтой.